

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/077/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот</p> <p>2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665, Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 261885, Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Батхишиг Утас: 261740, Цахим хаяг: batkhishigb@audit.gov.mn</p> <p>Эйч Эл Би Монголиа Аудит ХХК Захирал: Ч.Энхтуяа Утас: 9911 0581, Цахим хаяг: enkhtuya@hlab.mn</p>
	<p>Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.</p>

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТХГ	Тусгай Хамгаалалтын Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНБЦГ	Хөвсгөл Нуурын Байгалийн Цогцолборт Газар
ХУТХГ	Хөвсгөлийн Тусгай Хамгаалалтын Газар
ЧХАЖЦ	Чингис Хааны Аялал Жуулчлалын Цогцолбор



ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
П.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.23 № 07/1555
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл нь тайлант онд 7,626,890.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5 барилга, 1,693,923.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төрлийн 13 ширхэг тоног төхөөрөмж, нийт 9,320,813.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй барилга, тоног төхөөрөмжийг комиссын актаар баталгаажуулан хүлээн авч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл нь тайлант онд 10,783,739.6 мянган төгрөгийн гадаад зээлийн санхүүжилт авч, барилга байгууламжид 8,457,507.4

мянган төгрөг, бусад хөрөнгөд 464,490.3 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээнд 1,390,899.7 мянган төгрөг, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардалд 671,892.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нутгийн оршин суугчдад түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт болон чадавхыг сайжруулах арга хэмжээ 94.0 хувь, аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг байгуулах арга хэмжээ 48.2 хувь, хог хаягдлын менежментийг сайжруулах арга хэмжээ 97.0 хувь, тусгай хамгаалалтын газрын менежментийг бэхжүүлэх арга хэмжээ 68.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	28,776,369,982.31	36,938,550,116.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	872,372,823.30	692,649,823.99
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	872,372,823.30	692,649,823.99
31210	Төгрөг	666,255,481.31	349,097,613.96
31211	Төрийн сангийн харилцах	52,722,775.64	91,806,934.16
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	613,532,705.67	257,290,679.80
31220	Гадаад валют	206,117,341.99	343,552,210.03
31221	Төрийн сангийн харилцах	206,117,341.99	343,552,210.03
33	АВЛАГА	-	154,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	154,000.00
33101	Цалингийн авлага	-	154,000.00
34	УРЬДЧИЛГАА	7,210,000.00	2,332,808.35
34600	Урьдчилж гарсан зардал	7,210,000.00	2,332,808.35
35	БАРАА МАТЕРИАЛ	3,039,439.54	2,105,194.54
35400	Хангамжийн материал	3,039,439.54	2,105,194.54
35410	Бичиг хэргийн материал	136,100.00	97,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,903,339.54	2,007,694.54
36	НӨӨЦИЙН БАРАА	27,893,747,719.47	36,241,308,289.38
36800	Бусад эргэлтийн хөрөнгө (ТӨҮГ)	27,893,747,719.47	36,241,308,289.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	129,584,396.75	100,948,664.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	129,584,396.75	100,948,664.18
39200	Биет хөрөнгө	128,337,427.42	100,948,664.18
39203	Авто тээврийн хэрэгсэл	177,500,000.00	177,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(62,125,000.14)	(79,875,000.18)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	36,193,040.00	36,193,040.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,375,968.18)	(34,437,375.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,459,000.00	20,884,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,313,644.26)	(19,315,999.82)
39300	Биет бус хөрөнгө	1,246,969.33	-
39301	Программ хангамж	6,801,650.00	6,801,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,554,680.67)	(6,801,650.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	28,905,954,379.06	37,039,498,780.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	154,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	154,000.00
41300	Өглөг	-	154,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	154,000.00
41312	НДШ-ийн өглөг	-	-
41313	ХХОАТ-ын өглөг	-	154,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	28,905,954,379.06	37,039,344,780.44
51	Засгийн газрын хувь оролцоо	28,905,954,379.06	37,039,344,780.44
51200	Хуримтлагдсан үр дүн	28,905,954,379.06	37,039,344,780.44
51210	Өмнөх үеийн үр дүн	18,074,689,849.12	28,905,954,379.06
51220	Тайлант үеийн үр дүн	10,831,264,529.94	8,133,390,401.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	28,905,954,379.06	37,039,498,780.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,214,097,912.54	10,787,127,260.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,214,097,912.54	10,787,127,260.79
1200	Нийтлэг татварын бус орлого	13,214,097,912.54	10,787,127,260.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,213,423,592.54	10,783,739,578.79
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	13,213,423,592.54	10,783,739,578.79
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	-	2,711,550.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	674,320.00	676,132.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,385,739,517.26	2,667,557,737.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,385,739,517.26	2,667,557,737.72
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,385,739,517.26	2,667,557,737.72
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	305,425,148.27	404,150,307.00
210101	Үндсэн цалин	305,425,148.27	404,150,307.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,794,815.54	47,138,048.38
210201	Тэтгэврийн даатгал	25,961,137.61	31,740,386.09
210202	Тэтгэмжийн даатгал	3,054,251.48	4,041,503.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,443,401.19	2,020,751.54
210204	Ажилгүйдлийн даатгал	576,002.29	1,867,081.54
210205	Эрүүл мэндийн даатгал	5,760,022.97	7,468,326.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,587,000.00	81,244,717.57
210304	Байрны түрээс	62,587,000.00	81,244,717.57
2104	Хангамж, бараа материалын зардал	13,571,367.70	8,849,020.13
210401	Бичиг хэрэг	2,975,100.00	2,600,200.00
210402	Тээвэр, шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,374,267.70	5,879,806.13
210404	Ном, хэвлэл	3,772,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	450,000.00	369,014.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,736,900.00	8,556,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,700,000.00	4,036,000.00
210604	Урсгал засвар	5,036,900.00	4,520,600.00
2107	Томилолт, зочны зардал	86,462,414.00	84,966,097.00
210702	Дотоод албан томилолт	86,462,414.00	84,966,097.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	897,815,528.09	1,428,155,060.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	860,501,480.09	1,390,899,720.42
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,000,000.00	33,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,140,000.00	4,081,291.65
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	174,048.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	973,346,343.66	604,497,887.57

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	942,580,000.00	574,437,155.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	30,766,343.66	30,060,732.57
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	10,828,358,395.28	8,119,569,523.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	8,036,642.21	13,820,878.31
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	8,036,642.21	13,820,878.31
145	Бусад орлого (олз)	8,036,642.21	13,820,878.31
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	8,036,642.21	13,820,878.31
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	5,130,507.55	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	5,130,507.55	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	671,944.55	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	4,458,563.00	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	10,831,264,529.94	8,133,390,401.38

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,230,078,776.41	2,195,486,088.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,230,078,776.41	2,195,486,088.33
1200	Нийтлэг татварын бус орлого	2,230,078,776.41	2,195,486,088.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,230,078,776.41	2,187,979,538.33
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,230,078,776.41	2,187,979,538.33
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	-	7,506,550.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,410,407,629.60	1,413,371,746.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,410,407,629.60	1,413,371,746.50
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,410,407,629.60	1,413,371,746.50
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	305,425,148.27	404,150,307.00
210101	Үндсэн цалин	305,425,148.27	404,150,307.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,944,371.54	47,138,048.38
210201	Тэтгэврийн даатгал	26,110,648.61	31,740,386.09
210202	Тэтгэмжийн даатгал	3,054,251.48	4,041,503.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,443,401.19	2,020,751.54
210204	Ажилгүйдлийн даатгал	576,047.29	1,867,081.54
210205	Эрүүл мэндийн даатгал	5,760,022.97	7,468,326.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,587,000.00	81,244,717.57
210304	Байрны түрээс	62,587,000.00	81,244,717.57
2104	Хангамж, бараа материалын зардал	13,663,467.70	8,810,420.13
210401	Бичиг хэрэг	3,067,200.00	2,561,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	5,879,806.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,374,267.70	-
210404	Ном, хэвлэл	3,772,000.00	369,014.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	450,000.00	8,556,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,736,900.00	4,036,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,700,000.00	-
210604	Урсгал засвар	5,036,900.00	4,520,600.00
2107	Томилолт, зочны зардал	84,235,214.00	83,394,320.00
210702	Дотоод албан томилолт	84,235,214.00	83,394,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	897,815,528.09	780,077,333.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	860,501,480.09	742,904,185.42
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,000,000.00	33,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,140,000.00	3,999,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	174,048.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	819,671,146.81	782,114,341.83
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,072,265,316.48	975,658,219.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,072,265,316.48	975,658,219.45
2200	Дотоод эх үүсвэрээр	1,072,265,316.48	975,658,219.45
220001	Барилга байгууламж	510,985,316.48	974,233,219.45
222001	Тоног төхөөрөмж	561,280,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,425,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(1,072,265,316.48)	(975,658,219.45)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	3,578,079.21	13,820,878.31
14	Бусад эх үүсвэр	8,036,642.21	13,820,878.31
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	8,036,642.21	13,820,878.31
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	4,458,563.00	-
25001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	4,458,563.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	(249,016,090.46)	(179,722,999.31)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,121,388,913.76	872,372,823.30
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	872,372,823.30	692,649,823.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгсгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	18,074,689,849.12	18,074,689,849.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	18,074,689,849.12	18,074,689,849.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	10,831,264,529.94	10,831,264,529.94
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	28,905,954,379.06	28,905,954,379.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	28,905,954,379.06	28,905,954,379.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	8,133,390,401.38	8,133,390,401.38
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	37,039,344,780.44	37,039,344,780.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,155,700,000.00	10,984,790,006.41	170,909,993.59	98.5
УРСГАЛ ЗАРДАЛ	2,169,710,000.00	2,062,792,281.50	106,917,718.50	95.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,169,710,000.00	2,062,792,281.50	106,917,718.50	95.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,589,200.00	404,150,307.00	438,893.00	99.9
Үндсэн цалин	404,589,200.00	404,150,307.00	438,893.00	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,908,600.00	47,138,048.38	3,770,551.62	92.6
Тэтгэврийн даатгал	32,980,000.00	31,740,386.09	1,239,613.91	96.2
Тэтгэмжийн даатгал	4,446,000.00	4,041,503.07	404,496.93	90.9
ҮОМШӨ-ний даатгал	2,367,700.00	2,020,751.54	346,948.46	85.3
Ажилгүйдлийн даатгал	2,223,000.00	1,867,081.54	355,918.46	84.0
Эрүүл мэндийн даатгал	8,891,900.00	7,468,326.14	1,423,573.86	84.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,000,000.00	81,244,717.57	755,282.43	99.1
Байрны түрээс	82,000,000.00	81,244,717.57	755,282.43	99.1
Хангамж, бараа материалын зардал	9,600,000.00	8,810,420.13	789,579.87	91.8
Бичиг хэрэг	2,600,000.00	2,561,600.00	38,400.00	98.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,100,000.00	5,879,806.13	220,193.87	96.4
Ном, хэвлэл	450,000.00	-	450,000.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	450,000.00	369,014.00	80,986.00	82.0
Эд хогшил, урсгал засварын зардал	10,525,000.00	9,981,600.00	543,400.00	94.8
Багаж, техник хэрэгсэл	4,100,000.00	4,036,000.00	64,000.00	98.4
Тавилга	1,425,000.00	1,425,000.00	-	100.0
Урсгал засвар	5,000,000.00	4,520,600.00	479,400.00	90.4
Томилолт, зочны зардал	182,506,300.00	83,394,320.00	99,111,980.00	45.7
Дотоод албан томилолт	182,506,300.00	83,394,320.00	99,111,980.00	45.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,429,581,000.00	1,428,072,868.42	1,508,131.58	99.9
Бараа үйлчилгээний бусад зарда	1,390,906,000.00	1,390,899,720.42	6,279.58	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,000,000.00	33,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	4,500,000.00	3,999,100.00	500,900.00	88.9
Тээврийн хэрэгслийн татвар	175,000.00	174,048.00	952.00	99.5

Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,000,000.00	-	1,000,000.00	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,985,990,000.00	8,921,997,724.91	63,992,275.09	99.3
Барилга байгууламж	8,500,990,000.00	8,457,507,427.66	43,482,572.34	99.5
Тоног төхөөрөмж	485,000,000.00	464,490,297.25	20,509,702.75	95.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,155,700,000.00	10,791,246,128.79	364,453,871.21	96.7
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	11,155,700,000.00	10,783,739,578.79	-	-
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	11,155,700,000.00	10,783,739,578.79	-	-
Бусад орлого	-	7,506,550.00	-	-
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	872,372,823.30	-	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	692,649,823.99	-	-
Тохируулгын дүн	-	13,820,878.31	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	10	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	9	9	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл нь зорилгоо “тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх үндэсний загварыг бий болгох, байгаль хамгаалал, аялал жуулчлал, эдийн засгийн асуудлыг цогцоор шийдвэрлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тус төсөл нь 2019 оны 8 дугаар сарын 06-ны өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Азийн Хөгжлийн Банкны 38,000.0 мянган ам.долларын санхүүжилтээр 4 зорилтын хүрээнд Хөвсгөл, Хэнтий аймагт орших байгалийн цогцолборт газруудын дэд бүтэц, ариун цэврийн байгууламжийг сайжруулах, аялал жуулчлалын салбарын өсөлтөд тогтвортой менежмент хийх чадварыг нь дээшлүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээн дэх эдийн засгийн хувьд хүртээмжтэй аялал жуулчлал, байгаль орчны хамгааллыг цогцлоосон жишиг байгалийн цогцолборт газрууд болгон өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдөж ажилладаг.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл нь Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг байна.

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон;
- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон;
- Шилэн дансны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” А52 дугаар тушаал;
- Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ний өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны 01 сарын 03-ны өдрийн А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ын журам”

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх

үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч болох Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас 2024 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайланг, Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,133,544.5 мянган төгрөгөөр буюу 28.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	872,372.8	692,649.8	(179,723.0)
Авлага	-	154.0	154.0
Урьдчилж гарсан зардал	7,210.0	2,332.8	(4,877.2)
Бараа материал	3,039.4	2,105.2	(934.2)
Бусад эргэлтийн хөрөнгө	27,893,747.7	36,241,308.3	8,347,560.6
Үндсэн хөрөнгө	129,584.4	100,948.7	(28,635.7)
Нийт хөрөнгийн дүн	28,905,954.3	37,039,498.8	8,133,544.5
Богино хугацаат өр төлбөр	-	154.0	154.0
Засгийн газрын хувь оролцоо	28,905,954.3	37,039,344.8	8,133,390.5
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	28,905,954.3	37,039,498.8	8,133,544.5

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 692,649.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 179,723.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс 2,187,979.5 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, тендерийн баримт бичиг худалдсанаас 2,711.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, түрээсийн барьцаа хөрөнгө 4,795.0 мянган төгрөг чөлөөлж, 13,820.9 мянган төгрөгийн валютын ханшийн зөрүүний олзыг хүлээн зөвшөөрч, гэрээт ажлын санхүүжилтэд 974,233.2 мянган төгрөг олгож, урсгал зардалд 1,413,371.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө худалдан авахад 1,425.0 мянган төгрөг зарцуулсан зэрэг нь нөлөөлсөн байна.
- Авлага дансны үлдэгдэл 154.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 154.0 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ хөнгөлөлттэй холбоотой ажилчдаас авах авлага байна.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 2,332.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,877.2 мянган төгрөгөөр буурсан нь шинээр 3,999.1 мянган төгрөгийн даатгалын гэрээ байгуулж, 2,415.0 мянган төгрөгийн даатгалын зардлыг бууруулж, 4,795.0 мянган төгрөгийн түрээсийн барьцаа чөлөөлөгдсөнтэй холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 2,105.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 934.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 21,599.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 676.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, 23,209.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.
- Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 36,241,308.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,347,560.6 мянган төгрөгөөр өссөн нь төслийн хүрээнд хэрэгжиж буй барилга угсралтын дуусаагүй ажлуудын гүйцэтгэлийг хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 100,948.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 28,635.7 мянган төгрөгөөр буурсан нь 1,425.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 30,060.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос шалтгаалсан байна.
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 154.0 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын өглөгтэй холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 37,039,344.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,133,544.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 54,835,711.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн саналаас урсгал зардлыг 1,591,150.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 42,088,860.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж 11,155,700.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Улсын их хурал, Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авч байгаа арга хэмжээтэй холбогдуулан төсвийг танасан ба хөрөнгийн зардлын хувьд зарим барилгын ажлууд эхлэх байсан боловч зураг төслөөс шалтгаалан хойшлогдсонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс Азийн Хөгжлийн Банкны шууд төлөлтөөр 8,595,760.1 мянган төгрөг, мөнгөн орлогоор 2,187,979.5 мянган төгрөг нийт 10,783,739.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардал 10,984,790.0 мянган төгрөг буюу 98.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Цалингийн зардалд 451,288.4 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 9,981.6 мянган төгрөг, түрээсийн зардалд 81,244.7 мянган төгрөг, хангамжийн зардалд 8,810.4 мянган төгрөг, томилолтын зардалд 83,394.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 1,428,072.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 8,921,997.7 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70207	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	11,155,700.0	10,984,790.0	170,910.0	98.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл нь 2024 онд баталсан төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжих хугацаанд 4 зорилт хөтөлбөрийн хүрээнд 13 үр дүнд хүрэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжилтийн явц /хувь/
	Нутгийн оршин суугчдад түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт болон чадавхыг сайжруулах	94.0
	Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг байгуулах	48.2
	Хог хаягдлын менежментийг сайжруулах	97.0
	ТХГ-ын менежментийг боловсронгуй болгох	68.0

Зорилт 1: Нутгийн оршин суугчдад түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт болон чадавхыг сайжруулах

- 1.1. Төслийн “Олон нийтийн санаачилгаар төлөвлөж хэрэгжүүлэх аялал жуулчлалын жишиг арга хэмжээ, төсөлд дэмжлэг үзүүлэх” ажлын хүрээнд 2024 онд нийт 9 ажил төлөвлөгдсөн. Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх 8 ажлыг 4 гэрээнд багцалж тендер сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна. Тус зорилтын түвшний гэрээт ажлуудын хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын “Жанхайн давааны худалдааны төв” тохижуулах ажлыг эхлүүлж, явган зам талбай, тохижилт болон гадна дотор цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн материал татан авалтууд хийсэн, хяналтын камерууд суурилуулсан бөгөөд нийт хэрэгжилт 14.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Гэрээт ажил буюу хяналтын камер нийлүүлж, талбайд суурилуулах ажил 100 хувьтай бүрэн дууссан тул гэрээг дүгнэж хаасан байна.
- 1.2. Төслийн “Олон нийтийн санаачилгаар төлөвлөж хэрэгжүүлэх аялал жуулчлалын жишиг арга хэмжээ, төсөлд дэмжлэг үзүүлэх” ажлын хүрээнд Хэнтий аймгийн Дадал суманд CP1-7 гэрээ болох “Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмж нийлүүлэх” ажил 100 хувьтай бүрэн дууссан тул гэрээг дүгнэжээ.
- 1.3. Хэнтий аймаг дахь Түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын аяллын маршрут, бүтээгдэхүүн, үйлчилгээг Google платформд оруулах зөвлөх үйлчилгээний тендер сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байгаа бөгөөд 1 дүгээр шатны үнэлгээг АХБ-нд хүргүүлсэн.

- 1.4. “Чингис хаан” аялал жуулчлалын цогцолборын Менежментийн байгууллага байгуулах ажлын хүрээнд байгууллагын өмчийн хэлбэрийг тодорхойлох хэлэлцүүлгийг БОАЖЯ, ЕСАА, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, ЧХӨСХ, СӨҮТ, АЖҮХ, Хэнтий аймгийн ЗДТГ-ын төлөөллийг хамруулан зохион байгуулсан байна.

Зорилт 2: Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг байгуулах

- 2.1. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт байгуулж буй 37.9 км авто зам, 7 зогсоолын гэрээт ажлыг 50 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, буталсан чулуун суурь дэвсэх, замын хөвөө дүүргэх, давуулах далан цутгах, ус зайлуулах хоолой сунгах ажлууд хийгдсэн бөгөөд 2024 оны зам барилгын ажлыг 10 дугаар сарын 25-ны өдрөөр зогсоож барилгын ажил хийгдэхгүй хугацаанд замуудын трасс дагуух хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулсан байна. Мөн тус гэрээт ажлын 2024 оны гүйцэтгэл болон үлдэгдэл ажлыг дүгнэх, 2025 оны зам барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хаах, 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлуудыг хийсэн байна.
- 2.2. Дадал сумын төвөөс “Чингис хаан” аялал жуулчлалын цогцолбор (ЧХАЖЦ) хүртэлх 1.9 км авто зам, зогсоолын барилга угсралтын ажлын тендерийн баримт бичгийг боловсруулж дуусган, зарлан, сонгон шалгаруулж 2024 оны 12-р сарын 02-ны өдрөөр 24/549 тоот гэрээг байгуулсан байна.
- 2.3. Хэнтий аймгийн Дадал суманд хэрэгжүүлж буй “Чингис хаан” аялал жуулчлалын цогцолборын гэрээт ажлын нийт хэрэгжилт 18 хувийн гүйцэтгэлтэй байна. Цогцолборын ажлын зураг төслийг магадлалаар оруулж 3 дугаар сард батлуулсан бөгөөд төсвийг магадлалаар хянуулахаар өгсөн байна. Мэдээллийн төвийн барилга угсралтын ажил 28 хувийн гүйцэтгэлтэй, барилгын үндсэн каркасны бетон цутгалт, арматур зангидах ажлууд хийгдсэн бөгөөд 2024 оны барилга угсралтын ажлыг 11 дүгээр сарын 14-ний өдрөөр зогсоосон байна. Цогцолборын зураг төслийн ажлын гүйцэтгэлийг дүгнэх, хүлээн авах ажлын хэсэг БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын ДА/438 тоот тушаалаар байгуулагдсан байна. Ажлын хэсгээс зураг төсөл болон гэрээт ажлын хэрэгжилт, үлдэгдэл ажлыг дүгнэх зорилгоор хэд хэдэн удаагийн хурал уулзалтыг зохион байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтийг захиалагч яамтай хамтран дүгнэх ажил хийгдсэн байна.

Зорилт 3: Хог хаягдлын менежмент сайжруулах

- 3.1. Хөвсгөл аймгийн Мөрөн хотын төвд нийтийн Ариун цэврийн байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлэн 15 хувьтай, Алаг-Эрдэнэ сумын Жанхайн давааны нийтийн Ариун цэврийн байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлэн 15 хувийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжүүлж, байгууламжийн газар шороо, суурийн цутгалтын ажлууд хийгдсэн бөгөөд 2024 оны барилга угсралтын ажлыг 10 дугаар сарын 25-ны өдрөөр зогсоосон байна. Барилга угсралтын ажлын хүрээнд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг хуралдуулж дүгнүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Мөн тус гэрээт ажлын 2024 оны гүйцэтгэлийг дүгнэх, 2025 оны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж ажилласан байна.
- 3.2. Төслийн хүрээнд тус онд 3 Хатуу хог хаягдлын лансфилл байгууламжийн барилга угсралтыг 100 хувь гүйцэтгэж дуусган, Хэнтий аймгийн Дадал суманд 7 дугаар сард, Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 7 дугаар сард, Ханх суманд 11 дүгээр сард тус тус Улсын комисс ажиллуулж, ашиглалтад бүрэн хүлээлгэн өгсөн байна. Ингэснээр төслийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах” Зорилт-3-ын хүрээнд хатуу хог хаягдлын Лансфилл байгууламжууд барих, хуучин хогийн цэгүүдийг нөхөн

сэргээх, машин, тоног төхөөрөмжүүд нийлүүлэх, ашиглагч байгууллагыг чадавхжуулах, ашиглалт засвар үйлчилгээний гарын авлага өгөх А3 багц 22/96 тоот гэрээт ажил 2022-2024 оны хооронд хэрэгжиж дууссан тул гүйцэтгэгч байгууллагатай эцсийн тайлан, гүйцэтгэл, баримт бичгийн бүрдлийг хүлээлцэж, гэрээг дүгнэж, акт үйлджээ.

- 3.3. Мөн тус онд 2 Бохир цэвэрлэх байгууламжийн барилга угсралтыг 100 хувь гүйцэтгэж дуусган, Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 7 дугаар сард, Ханх суманд 11 дүгээр сард тус тус Улсын комисс ажиллуулж, ашиглалтад бүрэн хүлээлгэн өгсөн байна. Ингэснээр төслийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах” Зорилт-3-ын хүрээнд Бохир ус цэвэрлэх байгууламж барих, машин нийлүүлэх, ашиглагч байгууллагыг чадавхжуулах, ашиглалт засвар үйлчилгээний гарын авлага өгөх А6 багц 22/181 тоот гэрээт ажил 2022-2024 оны хооронд хэрэгжиж дууссан тул гүйцэтгэгч байгууллагатай эцсийн тайлан, гүйцэтгэл, баримт бичгийн бүрдлийг хүлээлцэж, гэрээг дүгнэж, акт үйлдсэн байна.

Зорилт 4: Тусгай хамгаалалтын газрын менежментийг боловсронгуй болгох

- 4.1. А1 багц гэрээт ажил болох “Хөвсгөлийн Улсын Тусгай Хамгаалалттай Газрын Хамгаалалтын захиргааны оффис/жуулчны мэдээллийн төвийн барилга, төлбөр авах цэг, нийтийн ариун цэврийн байгууламжуудын барилга угсралт”-ын ажил гүйцэтгэгчийн тендер сонгон шалгаруулалтыг дуусгаж, гэрээлэн, ажлыг эхлүүлсэн байна. Хөвсгөлийн Улсын Тусгай Хамгаалалттай Газрын Хамгаалалтын захиргааны оффис/жуулчны мэдээллийн төвийн барилга угсралтын ажлыг 15 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, газар шороо, барилгын суурь цутгалт, 4.5км кабель татах, булах, 0.4/35кв дэд өртөө байгуулах, цэвэр усны гүний худгийн байгууламжийн ажлуудыг хийж дуусгасан бөгөөд 2024 оны барилга угсралтын ажлыг 10 дугаар сарын 25-ны өдрөөр зогсоож барилга угсралтын ажлын хүрээнд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг хуралдуулж дүгнүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Мөн тус гэрээт ажлын 2024 оны гүйцэтгэлийг дүгнэх, 2025 оны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргах ажил хийгдсэн байна.
- 4.2. Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын Менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2021 оны А/16 тоот тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй”-н дагуу боловсруулж, батлуулсан байна.
- 4.3. “Нутгийн оршин суугчдад түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт болон чадавхыг сайжруулах” төслийн Зорилт-1 болон “Тусгай хамгаалалттай газрын менежментийг боловсронгуй болгох” Зорилт-4-ийн хүрээнд ЗҮ16 багц “Эко аялал жуулчлалын төлөвлөлтийн зөвлөх үйлчилгээ”-ний гэрээт ажлыг хэрэгжүүлсэн байна. Тус зөвлөх үйлчилгээний хүрээнд 4 жилийн хугацаанд орон нутгийг аялал жуулчлал, хог хаягдлын чиглэлээр чадавхжуулах, байгалийн цогцолборт газрын менежментийг боловсронгуй болгох, бодлогын баримт бичгүүд боловсруулах, судалгаа зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, Төслийн хугацаанд батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг болон Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Пүрэвсүрэн, аудитор Ц.Мягмарсүрэн, П.Ганчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер А.Билгүүн, захирал Ч.Энхтуяа нар анхан шатны хяналтыг, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Б.Батхишиг, ахлах аудитор Ц.Батсүх, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 25/31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,667,557.74 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 26,675.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь хуулийн хэрэгжилтийг хангаж, зардлыг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд тайлант хугацаанд нийт 171 мэдээллийг хугацаандаа байршуулж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 65,232.5 мянган төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлэхгүй байгаа зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1. Төслийн Удирдах Хорооны 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан Төслийн 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ХУТХГ-ын хамгаалалтын захиргаа ба мэдээллийн төвийн барилга угсралт, Мөрөнгийн талбайн тохижилт, Ханх сумын төлбөр авах цэгийн барилга угсралт болон Хөвсгөл аймгийн жижиг байгууламжууд /орлого бий болгох, орон нутгийн бүтээгдэхүүнийг борлуулах, аялал жуулчлалын улирлыг уртасгах/ зэрэг нийт 676,770.0 мянган төгрөгийн ажлууд тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7. "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан "Гадаад зээлийн хөрөнгийн ашиглах эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих үнэлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2. "Төсөл арга хэмжээг тогтоосон хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх", 4.1.5. "Үйл ажиллагааны шуурхай хариуцлагатай тогтвортой байдлыг хангах" гэж тус тус заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4.4.2.2. Төслийн хэрэгжилт үр дүнтэй байгаа ч гүйцэтгэлийн хувьд тайланд хугацаанд өссөн дүнгээр санхүүжилтийн гүйцэтгэл 44.0 хувь, үйл ажиллагааны гүйцэтгэл 73.0 хувьтай байна.

Өгсөн зөвлөмж: Төслийн хугацаанд батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй, ил тод байдлыг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгах 77,291,727.8 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдан гарсан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	77,291,727.8	-	-	-
Нийт дүн	1	77,291,727.8	-	-	-

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төслийн хэрэгжилтийн төлөвлөгөөний дагуу барилгын ажил болон чадавхыг бэхжүүлэх ажлууд нь 2025 онд дуусахаар төлөвлөсөн байгаа тул тэдгээрийн үр дүн болон хэрэгжилтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Шилэн дансны нэгдсэн системд тайлант хугацаанд нийт 171 мэдээллийг хугацаандаа байршуулж, 65,232.5 мянган төгрөгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 8 мэдээллийг байршуулаагүй байна.	1	65,232.5	-	-	1	65,232.5	-	-
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
2	Төслийн Удирдах Хорооны 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан Төслийн 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ХУТХГ-ын хамгаалалтын захиргаа ба мэдээллийн төвийн барилга угсралт, Мөрөнгийн талбайн тохижилт, Ханх сумын төлбөр авах цэгийн барилга угсралт болон Хөвсгөл аймгийн жижиг байгууламжууд /орлого бий болгох, орон нутгийн бүтээгдэхүүнийг борлуулах, аялал жуулчлалын улирлыг уртасгах/ зэрэг нийт 676,770.0 мянган төгрөгийн ажлууд тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу хийгдээгүй байна.	1	676,770.0	-	-	-	-	1	676,770.0
3	Төслийн хэрэгжилт үр дүнтэй байгаа ч гүйцэтгэлийн хувьд тайланд хугацаанд өссөн дүнгээр санхүүжилтийн гүйцэтгэл 44.0 хувь, үйл ажиллагааны гүйцэтгэл 73.0 хувьтай байна.	-	-	-	-	-	-	1	-
	Дүн	3	742,002.5	-	-	1	65,232.5	2	676,770.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 993/20150458

Улаанбаатар хот

СНБТ- 0025/077/НА-СТА ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд тайлант хугацаанд нийт 171 мэдээллийг хугацаандаа байршуулж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 65,232,500.00 /Жаран таван сая хоёр зуун гучин хоёр мянга таван зуун/ төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: ...6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлэхгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн зохицуулагч /П.Түвшинжаргал/, төслийн санхүүгийн мэргэжилтэн /Б.Энхтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Ч.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9023030583

Z:\Alban Shaardlaga\2025\0422 SNAG-2.Docx